

**ХОВД АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
2020 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД БИЕ ДААННЭР ДЭВШИГЧ
ЭРДЭНЭБААТАР ОВОГТОЙ БАТЗАЯАГИЙН
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Ховд хот

2020.06.30

Нэр дэвшигч Эрдэнэбат овогтой Батзаяа миний бие нь Монгол улсын Үндсэн хууль, Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Сонгуулийн тухай хууль болон бусад хууль, тогтоомжийн хүрээнд 2020-2024 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрөө

- Монгол хүн-үндэстний үнэт зүйл гэж тодорхойлж байна.

Мөрийн хөтөлбөр боловсруулахад бодит үндэслэл бүхий тооцоо судалгаатай, улс, орон нутгийн ирээдүйн хөгжлийг хэтийн төлөвийг тодорхойлсон урт, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдийг гол чиг баримжаагаа болгон эдийн засгийн хөгжлийг төлөвлөхдөө нэн тэргүүнд үндэсний аюулгүй байдал, Монгол улс оршин байхын үндэс, нүүдлийн соёл, өв уламжлал, түүнийг тээгч Монгол түмний эрх ашиг, бэлчээр нутаг, ус, байгаль экологийн тэнцвэрийг хангах, хүн амын амьжиргаа, ахуй амьдралыг нийтээр нь өөд татах, ажлын байрыг нэмэгдүүлэх, салбар бүрийн ажлын уялдаа, асуудлыг цогцоор нь харж, Монгол улсынхаа хувь заяаны төлөө энэхүү мөрийн хөтөлбөрөө танилцуулж байна.

Нэг. Монгол хүн-Үндэстний үнэт зүйл

Монгол Улсын үнэт зүйл, эрхэм дээд баялаг бол Монгол хүн юм. Төрийн бодлогын үндсэн гол цөм нь "Монгол хүн" байж, хуулиар хамгаалагдсан, төрийн ивээлд багтсан, хүн бүр адил тэгш эрхтэй, шударга нийгмийг цогцлоон хөгжүүлнэ.

Үүнд:


- 1.1 Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжоор Монгол хүний эрх, эрх чөлөө, аюулгүй байдлыг тэргүүнд тавьж, батлан хамгаалах чадавхийг бэхжүүлж, эрүүл орчин, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх;



- 1.2 Монгол хүний аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, халдлагын золиос болохоос хамгаалах, гэр бүлийн хүчирхийлэл, архи дан согтууралт, мансууралтай тэмцэх ажлыг эрчимжүүлж, нийгмийн хамгааллын үйлчилгээ нь баталгаатай хүртээмжтэй зорилтот бүлэгт чиглүүлэн ажиллах;
- 1.3 Монгол хүн амын өсөлтийг дэмжиж, хүний хөгжил, амьдралын чанарт дэвшил гаргах, хүн амын удмын санд учрах сөрөг нөлөөллийг бууруулах, эрүүл мэндийн даатгалд хамрагддаг эмчилгээ, үйлчилгээний хамрах хүрээг нэмэгдүүлэх, нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг дэмжих замаар эх, хүүхдийн эндэгдэлийг бууруулах;
- 1.4 Ажилгүйдэл, ядуурлыг бууруулан, хүн амын дундаж орлоготой хэсгийг нэмэгдүүлэх, иргэдийнхээ амьжиргааг сайжруулах төсөл, хөтөлбөрийг бүсчилсэн маягаар хийж, бодлого хэрэгжүүлэх, эрх зүйн орчинг боловсронгуй болгох;
- 1.5 Иргэний болон насан туршийн боловсролын тогтолцоо нь нээлттэй, тэгш, хүртээмжтэй, чанартай болгохоос гадна сургууль, сургуулийн орчин, дотуур байрыг Монгол хүүхдийн хөгжлийн төв болгох ажлыг бодлогоор дэмжих;
- 1.6 Дээд боловсролын тогтолцоонд өөрчлөлт хийж, шинжлэх ухааны тэнхимүүдийг сэргээн байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлнэ. Шинжлэх ухаанд суурилсан дээд боловсролыг хөгжүүлэх, шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн харилцан уялдааг хангах;
- 1.7 Монгол хүүхдийн оюуныг тэтгэсэн цахим спортыг зөв зохистой хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэхээс гадна туух, хэл, өв соёлоор дамжуулан сурган хүмүүжүүлэх, мэдлэгтэй, боловсролтой, бие даах чадвартай, эрүүл чийрэг, эерэг зан суртахуунтай, хүмүүжил, төлөвшилттэй, амьдрах ухаантай, эх оронч, үндэсний бахархалтай хүн болоход нь үйл ажиллагаагаа чиглүүлнэ.

ХОЁР. НЭР ДЭВШСЭН ТОЙРОГТ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ЧИГЛЭЛЭЭР:

Тойргийн сонгогчдынхоо итгэлийг дааж, хэлсэн үг, хийсэн зүйлдээ эзэн болж, аливаа асуудалд шинжлэх ухаанч байр сууринаас хандаж, судалгаа, шинжилгээнд тулгуурлан, уламжлалт ахуй болон шинэ үеийн техник, технологит



суурилсан хөгжлийн бодлого боловсруулна.

2.1 Хөгжлийн суурь хүчин зүйл болох дэд бүтцийн нэн тулгамдсан асуудлуудыг иргэдийн санал, хүсэлтэд нийцүүлэн төрийн бодлогыг дэмжих


2.2 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, зохистой хөдөлмөр, хувийн бизнес эрхлэх мэдлэг, ур чадвартай хүний нөөцийг бүрдүүлэх төрийн бодлогыг дэмжих

2.3 Хогны менежментийг сайжруулах, сэргээгдэх эрчим хүчийг дэмжих, дэвшилтэт технологи нэвтрүүлэх ажлыг бодлогоор дэмжих

2.4 Өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хөдөлмөр эрхлэх, нийгмийн үйлчилгээнд эрх тэгш оролцох боломж, нийгмийн баялгийн үр шимээс адил тэгш хүртэх таатай эрх зүйн орчинг бүрдүүлэх.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд нэр дэвшигч миний бие Монгол нутаг, Монгол уламжлал, Монгол ёс заншил, Монгол ахуйг ирээдүй хойч үедээ өвлүүлэн уламжлуулахын төлөө бүхий л оюун ухаан, бие сэтгэлээ зориулах болно.

Мөрийн хөтөлбөр боловсруулсан



Э.Батзаяа

8417143692
9066454

